

“ГАЗАР–УЛСЫН ҮНДЭС”

АЖИВЫН ЕРӨНХҮЙ ГАЗАР
ГАЗРЫН ЗУРАГ, ГАЗРЫН
НЭРШИЛИЙН БАРИМТЫН
ҮЗЭСГЭЛЭН

МОНГОЛ УЛС

Улаанбаатар хот
2017.08.25

“Газар-Улсын үндэс” сэдэвт газрын зураг, газрын нэршилийн баримтын үзэсгэлэн

Бидний монголчуудын газар нутгийн дүр зураг, хилийн дээс нь эртний Хүннү гүрний үеэс бүрэлдсэн баримттай бөгөөд энэ нь XVII зууны эхний хагас хүртэл үндсэндээ хадгалагдсаар иржээ.

XVI зууны дундуур Гэрсэнз жалайр хунтайжийн эзэмшлийг 7 хөвгүүнд нь хуваан захируулснаар Халхын 7 хошуу, Халхын анхны 3 аймгийн эх үүсвэр тавигджээ. 1691 онд Манж Чин улсад Халх Монгол дагаар орсны дараа Манжийн төрөөс Халхын хошуудыг жижиглэн олшруулснаар хошуудын тоо 86-д хүрч, мөн Ховдын хязгаарыг байгуулан шинээр хошуудыг байгуулах болсноор Ар Монголын аймаг, хошуудын хилийн заагийг нарийн тодорхой болгож, хилийн овооны цэс үйлдэж, баталгаажуулах шаардлага гарсан. Энэ шаардлагын үүднээс аймаг, хошуу, өртөө, харуулын газрын зураг, нутгийн цэсийг үйлдэж ирсэн нь эдүгээ Монголын түүх судлалын судалгааны чухал сурвалж болжээ.

Монголчуудын бүтээж ирсэн газрын зурагт нутгийн хил хязгаар, уул ус, гол горхи, булаг шанд, сүм хийд, зам харгуйг тэмдэглээд зогсохгүй уул нь хэр өндөр модтой, нуур нь хэр гүн ба шорвог, гол мөрөн гэхэд урсгалын чиг зэргийг нарийн заадаг уламжлалтай байжээ. Монголчууд газрын зургаа ихэвчлэн цагаан даавуу, муутуу цаасан дээр өнгө ялган үйлдэх бөгөөд тийнхүү өнгө ялгахдаа дураар өнгө будаг тавьдаггүй журамтай байв. Жишээлбэл, хилийн шугам, харуул, өртөө зэргийг их төлөв улаан заримдаа хараар, замыг шараар, гол мөрөн, нуурыг хөх цэнхэрээр, элсэн манханыг цөлөвтөр газрыг ягаавтар өнгөөр, бэлчээр болон ой модыг ногоон өнгөөр зурж, тэмдэглэж заншжээ.

Үндэсний төв архивын сан хөмрөгт монголчуудын газрын зурагт холбогдох баримтуудыг нэгтгэсэн “Газрын зургийн цуглуулга”/X №460/ гэдэг биеэ даасан цуглуулга хөмрөг буй. Энэ хөмрөгт нийт 281 хадгаламжийн нэгж бүртгэгдсэн байна.

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүх, археологийн хүрээлэн, Олон улсын монгол судлалын холбоо, Монгол газар нутгийн нэрийн судлалын холбоо, Япон улсын Токиогийн Гадаад судлалын их сургууль хамтран 2017 оны 8 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулж буй **“Монголын газрын зураг, газрын нэр судлал”** сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд зориулан Архивын ерөнхий газраас **“Газар-Улсын үндэс”** сэдэвт газрын зураг, газрын нэршилийн баримтын үзэсгэлэнг Монголын олон нийтэд толилуулахаар бэлтгэж байна. Тус үзэсгэлэнгийн үзмэрүүд нь:

- 1. Манжийн эрхшээлийн үеийн Монголын газрын зураг, газар усны нэршил**
(XVIII зуунаас- XX зууны эхэн)
- 2. Шашин төрийг хослон барьсан Хаант Монгол улсын үеийн газрын зураг, газар усны нэршил** (1911-1921 он)

3. Монгол Улсын үеийн газрын зураг, газар усны нэршил (1921-2017 он) гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ.


Үзэсгэлэнд Архивын ерөнхий газрын Үндэсний төв архивын Түүхийн баримтын архив, Улс төрийн нам, олон нийтийн байгууллагуудын баримтын архив, Кино, гэрэл зураг, дуу авианы баримтын архив, Зураг төслийн баримтын архивын сан хөмрөг дэх газрын зураг, баримт бичиг, гэрэл зураг зэрэг ойролцоогоо 90 орчим үзмэр тавигдах болно.

Үзэсгэлэнгийн нээлт Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын үзэсгэлэнгийн танхимд 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 15:30-д болно.

Үзэсгэлэн дэлгэгдэх хугацаа: 2017.08.25-2017.09.20-ны өдрийг дуустал.




Үзэсгэлэнд тавигдсан зургуудаас



Сэцэн хан аймгийн Хурц вангийн хошууны нутгийн зураг. 1849 он. Цаасан зураг.





Сэцэн хан аймгийн Ёст бэйсийн хошууны нутгийн зураг. 1845 он. Цаасан зураг. МУУТА, Х.460, Д.1, ХН.10




Сэцэн хан аймгийн нутгийн хэмжээг тодорхойлсон зураг. 1885 он. Цаасан зураг. МУУТА, Х.460, Д.1, ХН.35



Засагт хан аймгийн Их хүрээний өмнө зүгийн зарим өртөөний нутгийн зураг. Он тодорхойгүй. Цаасан зураг. МУУТА, Х.460, Д.1, ХН.91





“Монголын газрын зураг, нэр судлал” олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд зориулан Архивын ерөнхий газраас зохион байгуулж буй архивын баримт бичгийн үзэсгэлэнд зориулан “Газрын зургийн цуглуулга” хөмрөгөөс авах газрын зургийн бүртгэл

Сэцэн хан аймгийн Жонон вангийн хошууны нутгийн зураг. 1791 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.1

Сэцэн хан аймгийн Ёст бэйсийн хошууны нутгийн зураг. 1845 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.10

Сэцэн хан аймгийн Сүжигт засгийн хошууны нутгийн зураг. 1845 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.12

Сэцэн хан аймгийн Далай дархан гүний хошууны нутгийн зураг. 1846 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.14

Сэцэн хан аймгийн Үйзэн вангийн хошууны нутгийн зураг. 1847 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.16


Сэцэн хан аймгийн Хурц вангийн хошууны нутгийн зураг. 1849 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.20

Сэцэн хан аймгийн Баатар вангийн хошууны нутгийн зураг. 1851 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.22

Сэцэн хан аймгийн Да вангийн хошууны туслагч Жигмэддорж, дэд Да гүнгийн хошууны туслагч Лутжаргал нарын хошууны заагаар чуулганы даргын газраас томилогдсон гүн Занашир, туслагч Үржинбадам нарын овоо байгуулж, хошууны нутгийн хил хязгаарыг тогтоосон зураг. 1860 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.24

Сэцэн хан аймгийн Бишрэлт вангийн хошууны нутгийн зураг. 1864 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.26

Түшээт хан аймгийн Пунцаглин хийд болон Гэсэр сүмийн хадлан тарианы газрын зураг. 1867 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.33



Сэцэн хан аймгийн нутгийн хэмжээг тодорхойлсон зураг. 1885 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.35

Сэцэн хан аймгийн Илдэн жүн вангийн хошууны нутгийн зураг. 1890 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.45

Сэцэн хан аймгийн Сэцэн ханы хошууны нутгийн зураг. 1890 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.50

Түшээт хан аймгийн Жонон засгийн хошууны нутгийн зураг. 1907 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.65

Түшээт хан аймгийн Эрдэнэ далай засгийн хошууны зураг. 1907 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.71

Сэцэн хан аймгийн Сэцэн ханы хошууны нутгийн зураг. 1909 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.1, ХН.77

Сэцэн хан аймгийн Хурц засгийн хошууны нутгийн зураг. 1913 он. Даавуун зураг.
МУУТА, Х.460, Д.2, ХН.3

Сайн ноён хан аймгийн Зоригт засгийн хошууны нутгийн зураг. 1913 он. Даавуун зураг.
МУУТА, Х.460, Д.2, ХН.4

Өөртөө эзэрхсэн Гадаад Монголын нутгийн зах хязгаарыг тодорхойлсон зураг. 1915 он. 1915 оны февраль сарын 13-ны өдөр цугласан Хиагтын гурван улсын хэлэлцсэн 33 дугаар хурлын бичиг.
МУУТА, Х.460, Д.2, ХН.6

Сайн ноён хан аймгийн Үйзэн засгийн хошууны нутгийн зураг. 1919 он. Цаасан зураг.
МУУТА, Х.460, Д.2, ХН.9

Сайн ноён хан аймгийн Баатар засгийн хошууны нутгийн зураг. 1921 он. Даавуун зураг.
МУУТА, Х.460, Д.2, ХН.13

Түшээт хан аймгийн Хатанбаатар вангийн хошууны нутгийн зураг. Он тодорхойгүй.
МУУТА, Х.460, Д.2, ХН.18

Манжийн захиргааны үед Монгол нутагт байсан өртөө харуулын байршлын бүдүүвч зураг. Он тодорхойгүй. Цаасан зураг. МУУТА, Х.460, Д.1, ХН.88

Сэцэн хан аймгийн Хурц засгийн хошууны нутгийн зураг. 1890 он. Цаасан зураг. МУУТА, Х.460, Д.1, ХН.51

Засагт хан аймгийн Их хүрээний өмнө зүгийн зарим өртөөний нутгийн зураг. Он тодорхойгүй. Цаасан зураг. МУУТА, Х.460, Д.1, ХН.91

Нийслэл хүрээний баруун замын 11 босуулын өртөөний нутгийн зураг. 1914 он. Даавуун зураг. МУУТА, Х.460, Д.2, ХН.5

Сэцэн хан аймгийн Эрдэнэ Далай вангийн хошууны нутгийн зураг. 1921 он. Цаасан зураг. МУУТА, Х.460, Д.2, ХН.10



“Монголын газрын зураг, нэр судлал” олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд зориулан Архивын ерөнхий газраас зохион байгуулж буй архивын баримт бичгийн үзэсгэлэнд зориулан “Манжийн үеийн хөмрөг”-өөс авах баримт бичгийн бүртгэл

Засагт хан, Сайн ноён хан аймгийн да ван Мандарваа, засаг Хасбазар, Галдангүнтэв нарын гурван хошууны нутгийн зах нийлсэн Согоотын даваа, Ангирт нуур хоёр газрын овооны пайз мод энгийн түймэрийн галд түлэгдэж үгүй болсныг уул овооны газар шинэ тэмдэг мод байгуулсан явдлыг хоёр аймгийн чуулганы дарга нарын нэр хамт жанжин хэбэй амбас Танаа өргөсөн бичгийн эх.

Төр гэрэлтийн 17 дугаар оны 10 дугаар сарын 13.

МУУТА, ТБА, Х.М79, Д.1, ХН.46, Нугалбар-1

Харуул, хошуудын нутгийн хил, зах нийлсэн нутгийн дүрэм тогтоох талаар гүн Гунгаадорж, засаг Магсаржав нарын мэдүүлсний дагуу уг хэргийн эх гурван зүйлийг гүйцэтгэхээр дэд да хэбэй, дэд да гүн, хэбэй гүн нарт илгээсэн бичиг.

Түгээмэл элбэгтийн 7 дугаар оны цагаан сарын шинийн 4.

МУУТА, ТБА, Х.М79, Д.1, ХН.113, Нугалбар-2

Засагт хан аймгийн харъяат гүн Доржжав, засаг Гунгаадорж, засаг Магсаржав нарын зах нийлсэн хошуудын өөр өөрийн нутгийн нэрийг бичиж нутгийн нэрийг бичиж батлан мэдүүлсэн тул хэбэй гүн Са-аас харъяат аймгийн гүнгийн зэрэг Аюурзана нарын хамт, засаг тайж Банжавжаржав нарын хамтаар овоо тэмдгүүд босгосон тул Ялгуулсан хутагт болон түүний шавь нар амар тайван амьдрах, Шанзудва засаг лам нар хураамжлан захирахад харштай газаргүй болохыг Цэцэнлэгийн чуулган даргад илгээн зөвлөн тогтоосон бичиг.

Он цаг тодорхойгүй.

МУУТА, ТБА, Х.М79, Д.1, ХН.123, Нугалбар-1

Засагт хан аймгийн газар нутгийн төлөв байдлыг нарийн тодорхой зурж, газар нутгийн нэрийг оноон бичихийг тус аймгийн жанжин да-ийн газраас даалгасныг шалган үзээд хамтран хэлэлцэх зүйл байгааг зарагдсан элчээр хариу мэдэгдсэн хамаарсан да, дэд да нарын бичиг.

Бадаргуулт төрийн 34 дүгээр он.

МУУТА, ТБА, Х.М79, Д.1, ХН.271, Нугалбар-3

Хэбэй таван зэрэг нэмсэн, гурван зэрэг тэмдэглэсэн засаг улсад туслагч гүн Мандарваа түшмэд бид тушаасныг дагаж харъяат хошууны нутаг орны байдал

төлвийг магадлан байцааж уул усны нэр, хандах зүг чиг, хөндлөн гулд, зовхис өнцөг, найман замын хэмжээ зам тойрон тус аймгийн хошуудын нутагт зах нийлүүлэн байгуулсан овоодын нэр, хоорондын зүг чиг хэмжээ тэргүүтнийг цаг улиралын байдлын дагуу уг дүрэмд заасны ёсоор нийлүүлэн зурснаа мэдүүлсэн бичиг.
Бадаргуулт төрийн 17 дугаар он долдугаар сарын 10.

МУУТА, ТБА, Х.М78, Д.1, ХН.187, Нугалбар-1

Ялгуулсан хутагтын шавь нарт сонгосон нутаг нь Сайн ноён хан аймгийн засаг Бумдарийн хошуу нутгийн зах нийлж буй тул хилийн тэмдэг, овоо хэзээ, хэрхэн нийлэлцэхийг лавласан Заг голын гүнгээс Цэцэрлэгийн чуулганы газар илгээсэн бичиг.

Бадаргуулт төрийн 5 дугаар он есдүгээр сарын шинийн 8-наа.

МУУТА, ТБА, Х.М78, Д.1, ХН.166, Нугалбар-1

Зарлигаар тогтоосон зовхис хуваан зургийн дүрэм хэмжээг журамлан дагаж, харъяат аймгийн нутаг газар орны хэмжээ байдлыг сайхан нарийвчлан байцаалгаж уг дүрэм хэмжээнд нийлүүлэн зураг цэс үйлдэж түргэлэн мэдүүлэх явдлыг цөм урьд эдүгээн тушаасан ёсоор хянан нарийвчлан гүйцэтгэн мэдүүлж ирүүлэхийг гүн Дашдорж, туслагч түшмэд нарт тушаан илгээсэн Цэцэрлэгийн чуулган дарга нарын бичиг.

Бадаргуулт төрийн 17 дугаар он арван нэгдүгээр сарын шинийн 3.

МУУТА, ТБА, Х.М58, Д.2, ХН.221, Нугалбар-1

Засагт хан болон Сайн ноён хан аймгийн олон хошуудын газар орны зураг, цэс, батлах бичиг товч зураг зэргийн нарийн зуогийн байцаан үзсүгэй хэмээх манай яамнаа нэгэн хувийг нэмэн бэлтгэн хүргүүлбээс зохихыг Цэргийн хүрээний Монгол журганаас тус хоёр аймгийн эрхэм чуулган дарга нарт явуулсан бичиг.

Бүрэнт засагчийн 7 дугаар он гуравдугаар сарын 27.

МУУТА, ТБА, Х.М58, Д.2, ХН.163, Нугалбар-1

9 . Халхын Сайн ноён хан аймгийн Чуулганы дэд дарга Өөлдийн засгийн хошууны бэйс Чагдаржалын хошууны нутгийн доторх газрыг уг тушаасан ёсоор зарлигаар зарагдсан сайд нарын нэр зааж, зураг зурж батлан олгосон нутгийг эрхлэн сууж буйг тэмдэглэсэн цэс.

Бүрэнт засагчийн 3 дугаар он дөрөвдүгээр сарын 14.

МУУТА, ТБА, Х.М58, Д.2, ХН.149, Нугалбар-3

Халхын Сэцэн хан аймгийн үх хэлхээний газрын тодорхойлон бичсэн цэс бичиг.
Сайшаалтай Ерөөлтийн 10 дугаар он намрын тэргүүн сарын шинийн 4.

МУУТА, ТБА, Х.М31, Д.4, ХН.93, Нугалбар-2

Улсын судрын хүрээ ба Иргэнийг засах яамнаас улируулан байцаах олон зураг цэсийг цөм журганаас зааж тушаасан ёсоор өөр өөрийн нутгийн зураг зүйлийг тус бүр хошойгоод хувь үйлдэж, мэдүүлэн ирүүлэхээр олон хошуу энэ учир жанжин хэбэйд явуулан тушаах бичгийн эх.

Хэвт ёсны тэргүүн он арван хоёрдугаар сарын шинийн 8-нд.

МУУТА, ТБА, Х.М31, Д.5, ХН.416, Нугалбар-1

Цахар, Халхын зэрэг газар оронд буй олон ван, гүн, бэйл, бэйсий зэрэг түшмэд суусан газар орныхоо нэр, аль хошуу, газар нутгийн зах хязгаар болон нэрт уул, их гол, дөрвөн этгээдэд хэдэн газар зэргийг гэгэд нэгэнгүй тодорхойлон байцааж, өөр өөрийн засгийн нутгийн нэрийг уламжлан ирүүлэхийг Чуулганы дэд даргаас Халхын өмнөд цэргийг захирах туслагч жанжны газарт илгээсэн бичиг.

Тэнгэрийг тэтгэсэний 22 он арван хоёрдугаар сарын 29-нөө.

МУУТА, ТБА, Х.М32, Д.2, ХН.170, Нугалбар-1

Бэйс Гончигжав, гүн Гончигдорж нарын хоёр хошуу нутаг нийлэх газрыг хэлэлцэж тохирсонгүй учир бичиг өргөн ирснийг Хэрлэн барсын чуулган даргын газраас бэйс, гүн нарын биес нийлэн нутгийн зах хил хязгаарын тогтоонгүй учир аль сарын, аль өдөр хаана нийлэн шийтгэвээс зохистой явдлыг бэйс Гончигжав, гүн Гончигдорж нар нэгмөсөн тогтоон даруй хариу ирүүлтүгэй хэмээн илгээсэн бичиг.

Тэнгэрийг тэтгэсэний 58 он намын сүүл сарын 12-ноо.

МУУТА, ТБА, Х.М32, Д.2, ХН.528, Нугалбар-3

Сэцэн ханы зэрэг гурван хошууны зах нийлж, хил хязгаар газраа хойч өдөр байцаахад бат тэмдэг болгохын хэрэг, санаа нийлүүлэн эдүгээ зах хязгаарын зургийн газарт овоо нэмэн байгуулах нь эрхэм чухал болохыг Журганаа өргөн мэдүүлсэн Сэцэн ханы Хамаарсан чуулганы даргын бичиг.

Төр гэрэлтийн 15 дугаар он гуравдугаар сарын 17-ноо.

МУУТА, ТБА, Х.М32, Д.2, ХН.1357, Нугалбар-1

Бэйс Минжүүрдорж нараас нутгийн зураг балласан хэрэгт оролцох туслагч түшмэл Дуламжавын бие Сайр-Усын газар хэрэг нийлэхээр мордсон учрыг гаргаж Халхын өмнөд цэргийг захирагч туслагч жанжны газар хэбэй бэйл Га-ийн өргөсөн бичиг.

Бүрэнт засагчийн тэргүүн он гуравдугаар сарын 19.

МУУТА, ТБА, Х.М32, Д.2, ХН.2106, Нугалбар-28

Дотоод, гадаад олон газрын зургийг зуруулах тухай Дээд зарлигийг ёсоор болгож Хан уул, Хэрлэн Барс хотын хамаарсан чуулганы дарга нар болон Хүрээ хамаарсан шанзудба Дашдорж, Халхын дөрвөн аймгийн харуулыг бүгд захирах бэйс Цэдэвдорж, гүн Чимэддорж нарт тус тус яаравчлан тушаасан Олон улсын хэргийг ерөнхийлөн шийтгэх яамны бичиг.
Бүрэлт засагчийн 3 дугаар он.

МУУТА, ТБА, Х.М32, Д.2, ХН.2140, Нугалбар-1

Газар орны байдал дүрсийг тодорхойлон гаргаж зүйл ангийн хэргийг Журганаас заан тушаасан ёсоор олон хошууд өөр өөрийн нутгийн зургийн бүрнээ тодорхойлон байцааж зураг зурж, үгийг наалдуулан ялган салгаж цэс үйлдэж мэдүүлэхийг мэдэгдэн илгээсэн бичиг
Бадаргуулт төрийн 33 дугаар он хоёрдугаар сарын 30.

МУУТА, ТБА, Х.М32, Д.2, ХН.3647, Нугалбар-1

Их Журганаас тушаасны дагуу Монгол газар орны зах хязгаар газрын зураг цэсийг нарийвчлан үйлдэж мэдүүлэх зэрэг учрыг зарлан мэдэгдсэн Хэрлэн барсын чуулган даргын газрын албан бичиг.
Бадаргуулт төрийн 34 он арван хоёрдугаар сарын 14.

МУУТА, ТБА, Х.М32, Д.2, ХН.575, Нугалбар-1

Сэцэн хан аймгийн чуулганы газраас гаргасан туслагч Махбарид нараас Енчин зэрэг 7 харуулын овоо, хайч овоог цөм байгуулж, басхшш Соёлз уулын хормойгоос Тарвагатайн нуруу хүртэлх газар орны зураг зурж арилжин авав хэмээн чуулган даргын газраас мэдэгдсэн бичиг.
Төр гэрэлтийн 26 дугаар он тавдугаар сарын 18-наа.

МУУТА, ТБА, Х.М31, Д.3, ХН.817, Нугалбар-1

Сайн ноён хан аймгийн нутгийн хэцийг тогтоон бичиж өргөсөн дэвтэр данс.
Тэнгэр тэтгэсний 36 дугаар он цагаан сарын шинийн зургаанаа.

МУУТА, ТБА, Х.М58, Д.1, ХН.1

Сайн ноён хан аймгийн 24 засаг, 4 хутагтын шавь нарын эзэмшил нутгийн зах хязгаарыг ялган салгаж тогтоосон өргөх дэвтэр.
Сайшаалт Ерөөлтийн 10 дугаар он.

МУУТА, ТБА, Х.М58, Д.1, ХН.4

Халхын Сайн ноён хан аймгийн 24 засаг, 6 хутагтын шавь нарын нутаглах газар орны байдал дүрсийг дүрслэн Бадаргуулт төрийн 17 дугаар онд уг тогтоон тушаасан дүрмийн ёсоор нэг дөрвөлжин хэмжээнд 100 газар багтаан зурж ялган салгаж үйлдсэн цэс дэвтэр.

Бадаргуулт төрийн 33 дугаар он.

МУУТА, ТБА, Х.М58, Д.1, ХН.306

Засагт хан, Сайн ноён аймгийн да, ван Мандарваа, засаг Хасбазар, Галдангүнтэв нарын гурван хошууны нутгийн зах нийлсэн Согоотын даваа, Ангирт нуур хоёр газрын овооны пайз мод түймэрийн галд түлэгдэж үгүй болсон учир уул овооны газар шинэ тэмдэг мод байгуулсан явдлыг хоёр аймгийн чуулганы дарга нарын нэр хамт Улиастайн жанжин хэбэй амбас танаа өргөсөн бичгийн эх. 1937.11.14

МУУТА, ТБА, Х.М79, Д.1, ХН.46, Б.1

Харуул, хошуудын нутгийн хил, зах нийлсэн нутгийн дүрэм тогтоох талаар гүн Гунгаадорж, засаг Магсаржав нарын мэдүүлсний дагуу уг хэргийн эх гурван зүйлийг гүйцэтгэхээр дэд да хэбэй, дэд да гүн, хэбэй гүн нарт илгээсэн бичиг. 1857.01.30

МУУТА, ТБА, Х.М79, Д.1, ХН.113, Б.2

Засагт хан аймгийн харьяат ван Довчинжамц, гүн Доржжав, засаг Гунгаадорж, засаг Магсаржав нар зах нийлсэн хошуудын өөр өөрийн нутгаас зохихыг үзэж гаргасан нутгийн нэрийг бичиж батлан мэдүүлсэн тул хэбэй гүн Са-аас овоо тэмдгүүд босгож тул Ялгуулсан хутагт болон түүний шавь нар амар тайван амьдрах, шанзудва засаг лам нар хураамжлан захирахад харштай газаргүй болсныг Цэцэрлэгийн чуулган даргад илгээн зөвлөн тогтоосон бичиг. 1857 он

МУУТА, ТБА, Х.М79, Д.1, ХН.123, Б-1

Улсын судрын хүрээ ба Иргэнийг засах яамнаас улируулан байцаах олон зураг цэсийг цөм журганаас зааж тушаасан ёсоор өөр өөрийн нутгийн зураг зүйлийг тус бүр хошоод хувь үйлдэж, мэдүүлэн ирүүлэхээр олон хошуудад явуулан тушаах бичгийн эх. 1909.01.18

МУУТА, ТБА, Х.М31, Д.5, ХН.416, Б.1

Сэцэн ханы зэрэг гурван хошууны зах нийлж, хил хязгаар газраа хойч өдөр байцаахад бат тэмдэг болгохын хэрэг, санаа нийлүүлэн эдүгээ зах хязгаарын зургийн газарт овоо нэмэн байгуулах нь эрхэм чухал болохыг Журганаа өргөн мэдүүлсэн Сэцэн ханы аймгийн хамаарсан чуулганы даргын бичиг. 1835.05.02

МУУТА, ТБА, Х.М32, Д.2, ХН.1357, Б.1

Дотоод, гадаад олон газрын зургийг зуруулах тухай Дээд зарлигийг ёсоор болгож, Хан уул, Хэрлэн Барс хотын хамаарсан чуулганы дарга нар болон Хүрээ хамаарсан шанзудба Дашдорж, Халхын дөрвөн аймгийн харуулыг бүгд захирах бэйс Цэдэвдорж, гүн Чимэддорж нарт тус тус яаравчлан тушаасан Олон улсын хэргийг ерөнхийлөн шийтгэх яамны бичиг. 1864 он

МУУТА, ТБА, Х.М32, Д.2, ХН.2140, Б.1

Их Журганаас тушаасны дагуу Монгол газар орны зах хязгаар газрын зураг цэсийг нарийвчлан үйлдэж мэдүүлэх зэрэг учрыг зарлан мэдэгдсэн Хэрлэн барсын чуулган даргын газрын албан бичиг. 1908.01.06

МУУТА, ТБА, Х.М32, Д.2, ХН.575, Б.1

Сайн ноён хан аймгийн нутгийн хэцийг тогтоон бичиж өргөсөн дэвтэр данс. 1771.02.20

МУУТА, ТБА, Х.М58, Д.1, ХН.1

Сайн ноён хан аймгийн 24 засаг, 4 хутагтын шавь нарын эзэмшил нутгийн зах хязгаарыг ялган салгаж тогтоосон өргөх дэвтэр. 1805 он

МУУТА, ТБА, Х.М58, Д.1, ХН.4

Халхын Сайн ноён хан аймгийн 24 засаг, 6 хутагтын шавь нарын нутаглах газар орны байдал дүрсийг дүрслэн Бадаргуулт төрийн 17 дугаар онд уг тогтоон тушаасан дүрмийн ёсоор нэг дөрвөлжин хэмжээнд 100 газар багтаан зурж ялган салгаж үйлдсэн цэс дэвтэр. 1907 он

МУУТА, ТБА, Х.М58, Д.1, ХН.306

“Монголын газрын зураг, нэр судлал” олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд зориулан Архивын ерөнхий газраас зохион байгуулж буй архивын баримт бичгийн үзэсгэлэнд зориулан “Хаант Монголын үеийн хөмрөг”-өөс авах баримт бичгийн бүртгэл

A56-1-24 хуудас 83

Олон аймаг, хошуу, шавийн газрын зургийг уулын өндөр, ус нуурын өргөн уртыг хэмжээлэн зурж тушаан илгээхийг мэдүүлэн илгээсэн бичиг

Гуравдугаар он илүү арван хоёр сарын шинийн ёсөн

A3-1-1155 Нугалбар 2

Цэргийн хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамнаас Аймгийн чуулган дарга, аймаг, хошуу, шавь зэрэг олон газар орны газрын зургийг орон уул ус бэрх хэлбэр байдал дүрс хийгээд бас хүрээ хот хүртэл нарийвчлан зурж ирүүлэхийг тушаасан бичиг

Олноо өргөгдсөний 11 он 3 сарын 27

A11-2-502 Нугалбар 1

Баруун этгээдийн сэргийлэн тохинуулах цэргийн дайчлан захирах сайдаас дайснаас хамгаалах чухалтай бөгөөд харъяат олон аймгуудын газрын зураг чухал хэрэглэгдэх учир Түшээт, Сайн ноён хан хоёр аймгийн нутгийн зураг нэжгээд хувийг олгуулахыг мэдүүлэн ирсэн бичиг

Олноо өргөгдсөний 11 он 2 сарын шинийн 2

A11-2-112 Нугалбар 4

Дотоод хэргийн бүгд захиран шийтгэгч яамны журмыг дагаж өртөөний нутгийн хорогдолыг бусад өртөөний адил төв дундаас хааш хааш арван таваад газар хэмжээлж нутаг нэмэн олгож, хилийн овоо тэмдэг босгосон тухайн бичиг

Олноо өргөгдсний гуравдугаар он өвлийн сүүл сарын шинийн таван

A11-2-111 хуудас 21

Сангийн хамаг хэргийн бүгд захиран шийтгэгч яамны дэд сайд, Түшээт хан аймгийн цэргийн захирагч жанжин, улсад туслагч гүнгийн зэрэг Жүн засаг тэргүүн зэрэг тайж Ванчигравдангийн хошууны нутаг газар орны хэмжээ байдал төлөв, уул усны нэр тодорхойлон өргөсөн цэс

Олноо өргөгдсний гуравдугаар он илүү арван хоёр сарын арван хоёр

A29-2-202 Нугалбар 1

Хошууны нутаг угаас хөвч хангай өндөр бэрхийн дээр ногоо тачир, цас их орж гачигдсан учир сайд махасамади далай сэцэн ханы зэрэг арван долоон хошуунд илгээж нэр бүхий хошууны хүмүүсийг оторлон нүүж хүрсэн тухайд аль өвс бэлчээр зай завсар бүхий газраар нутаглуулан гачигдал үгүй буцааваас зохимой хэмээн илгээсэн бичиг

Долдугаар он 10 сарын 12

A29-2-292 худас 1

Хоёр зэрэг нэмсэн, нэг зэрэг тэмдэглэсэн бэйсийн зэрэг эрхэмсэг засаг улсын түшээ гүн Мишигдоржийн хошууны нутгийн хязгаар уулзах засаг хошууны овооны нэр тоо цэг зүг хэмжээг тодорхойлсон өргөх цэс

Олноо өргөгдсөний арван нэгдүгээр он зуны тэргүүн сарын хорин найман

A11-1-685 нугалбар 1

Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгийн олон хошуудын нутаг, Онон, Туул, Орхон, Сэлэнгэ гол зэрэг газар зураг авахаар одох харъяат хорооны Орос бичээч Цисеров түшмэл Шидалинов нарт үнэмлэх бичиг олгох тухай бичиг

Олноо өргөгдсөний гуравдугаар он зургаан сарын шинийн нэгэн

A11-1-471

Харчин умард засаг улсад туслагч гүн Дониддоржийн хошуунаас урьд Тэнгэрийг тэтгэсний 45 онд хэмжээлж олгосон нутгийн цэсийг ёсоор сийрүүлэн бичсэн цэс

“Монголын газрын зураг, нэр судлал” олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд зориулан Архивын ерөнхий газраас зохион байгуулж буй архивын баримт бичгийн үзэсгэлэнд зориулан “Ардын засгийн үеийн хөмрөг”-өөс авах баримт бичгийн бүртгэл

Богд хаан ууланд шагнасан Шашиныг тэтгэгч Их Богд хаан хайрхан цолыг Хан уулын чуулганы даргын шинэ тамганд бүрэн бичихэд үл багтах тул үгийг цөөтгөн Богд хаан хайрхан уулын чуулганы дарга хэмээн бичихийг зөвшөөрсөн Монгол Улсын Эзэн хаан VIII Богд Жибзундамба хутагтын зарлиг. 1912.01.16

МУУТА.ТБА.ХА-173.Д-1.ХН-77 Б.1

Засагт хан аймгийн чуулганы даргын тамганы дардас дахь Заг голын эх Биндэрьяа нуур хэмээх газар Сайн ноён хан аймгийн нутаг тул уг нэрийг халж, тамганы дардаст Хан тайшир уул хэмээн бич хэмээсэн Монгол Улсын Эзэн хаан VIII Богд Жибзундамба хутагтын зарлиг. 1912.05.27

МУУТА.ТБА.ХА-173.Д-1.ХН-85.Б.1

Шинээр байгуулах хошуудад хэмжээлэн зааж олгуулах нутаг газрыг тогтсон ёсоор зураг үйлтгүүлэхэд албаны хүмүүсийг томилсон тухай Дотоод яамнаас МАХН-ын Төв хороонд мэдэгдсэн бичиг. 1925.06.18

МУУТА.УТНОНББА. Х-4.Х-1.ХН-539

ЗОУ-ын мэргэжилтнүүдээр газрын зураг авахуулахыг зөвшөөрсөн тухай БНМАУ-ын Засгийн газрын 1925.09.14-ний 96 дугаар хурлын тогтоол.

МУУТА.ТБА. Х-1. Д-2.ХН-6 Х.251,257-259

“Монгол орны шинжилгээний ерөнхий байдал” хэмээх өгүүллийн эх 1931 он

МУУТА.ТБА.Х-23.Д-1.ХН-271

Шинээр байгуулах 13 аймгийн газар зүй, суурин газруудын далайн түвшнээс дээш өргөгдсөн байдлын тодорхойлолт, сумдын нэрийн жагсаалт, Газар зүйн кабинетын ажлын тайлан. Орос хэлээр. 1931 он.

МУУТА.ТБА.Х-23.Д-1.ХН-272

Засаг захиргааны шинэ анги, нутгийн зохион байгуулалтанд дагаж мөрдөх заавар, Завхан аймгийн засаг захиргааны шинэчлэлтийн тухай илтгэл. 1931 он

МУУТА.ТБА. Х-11. Д-1.ХН-214

Монголын газар нутгийн талаар шинжилгээ, судалгаа хийсэн тухай Шинжлэх Ухааны хүрээлэнгийн ажилтан А.Д.Симуковын илтгэл. 1933 он.

МУУТА.ТБА.Х-11. Д-1.ХН-260

Монгол Улсын Шинжлэх Ухааны хүрээлэнгийн Газрын зургийн тасгийн газрын зургийг бүртгэсэн данс. /Монгол бичгээр/ 1934 он.

МУУТА.ТБА.Х-23. Д-1.ХН-368

Монгол орны газар зүй, нийгэм эдийн засгийн байдлын тухай Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн А.Д.Симуковын бичсэн номын эх. Орос хэлээр. /Машиндсан/ 1934 он

МУУТА.ТБА.Х-23.Д-1.ХН-369

БНМАУ-ын нутаг дэвсгэрээс Хөлөн буйр, Шилийн гол, Алаша, Улаан цав, Өөлд зэрэг газрын нутаг дэвсгэр хүртэлх газрыг байцаан үзсэн данс. 1936 он.

МУУТА.ТБА.Х-23.Д-1.ХН-450

Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Газар зүйн тасгийн анхдугаар зөвлөгөөний холбогдох баримт. 1938 он.

МУУТА.ТБА.Х-23.Д-1.ХН-450

Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн ажилтан А.Д.Симуковын бичсэн зохиол бүтээлийн жагсаалт. 1938 он.

МУУТА.ТБА.Х-23. Д-1.ХН-516

А.Д. Симуковын гаргасан БНМАУ-ын 13 аймгийн тодорхойлолт. 1939 он /Оросоор, гар бичмэл/

МУУТА.ТБА.Х-23.Д-1.ХН-554

Архангай, Булган аймгийн хилийг топографийн арга дээр зурж авах, географийн нэрс болон тэмдгүүдийг тодотгох ажлаар явсан ШУХүрээлэнгийн Географийн кабинетын эрдэм шинжилгээний ажилтан Д.Бадамжавын тайлан. 1949 он.

МУУТА.ТБА. Х-23. Д-1.ХН-1076

Төв, Хэнтий, Сэлэнгэ аймгийн хилийг газрын зураг дээр тэмдэглэх ба географийн нэрс болон тэмдгүүдийг тодотгох ажлаар явсан ШУХүрээлэнгийн Географийн кабинетын эрдэм шинжилгээний ажилтан Д.Бадамжавын тайлан. 1950 он.

МУУТА.ТБА. Х-23. Д-1.ХН-1129

Богд уулыг Чойбалсангийн нэрэмжит уул болгох тухай БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг. 1952 2.22.

МУУТА.ТБА. Х-11. Д-2.ХН-59. Х.9

Зарим аймгуудын нутаг дэвсгэр засаг захиргааны хуваарьлалтад өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг. 1952 5.26.

МУУТА.ТБА. Х-11.Д-2.ХН-165. х.80-84

Богд уулыг Х.Чойбалсангийн нэрээр нэрлэх тухай БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1952 оны 8 дугаар зарлигийг хүчингүй болгосон БНМАУ-ын Ардын Их Хурлийн Тэргүүлэгчдийн зарлиг.

МУУТА.ТБА. Х-11.Д-2,ХН-541 х.46

